



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.07.07 № 27

Боловсролын хуулийн зарим заалтын
хэрэгжилтийн талаар

Боловсролын багц хуулийн хүрээнд зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа, хэрэгжилтийг хангаж ажиллахгүй байгаа учраас боловсролын салбарын бодлого, үйл ажиллагаа улам хүндрэлтэй болж байгаа талаар олон багш, судлаач санал гаргаж, гомдол ирүүлж байна.

Иймд Боловсролын багц хуулийн хэрэгжилт, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.8, 11.6-д тус тус заасан бөгөөд одоогийн байдлаар Ерөнхий боловсролын сургуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Сургалтын цөм хөтөлбөр” 2013-2014 оны хичээлийн жилээс бага боловсролд хэрэгжиж эхэлсэн. Хуулийн дээрх заалтын дагуу 2025-2026 оны хичээлийн жилд бага боловсролын суралцагчид шинэчилсэн хөтөлбөрөөр хичээллэх ёстой.

Боловсролын сайдын 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/101 дүгээр тушаалаар бага ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 2025-2026 оны хичээлийн жилд зөвхөн 1-2 дугаар ангид хэрэгжүүлэхээр баталж, 3-5 дугаар ангийн хөтөлбөрийн шинэчлэлийг хойшлуулж шийдвэрлэсэн байна. Гэтэл 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар А/101 дүгээр тушаалыг хүчингүй болгожээ.

Энэ нь Боловсролын сайдын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн “Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай” А/06 дугаар тушаалаар 254 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг хянах, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулж ажиллахдаа сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах ажлын явц, үр дүнг Боловсролын үндэсний зөвлөлд танилцуулах ажлыг зохион байгуулсан уу? Хэрэв танилцуулсан бол санал зөвлөмжийг шинэчилсэн хөтөлбөрт хэрхэн тусгасан талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Энэ хуулийн 7.3, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын

2025000040

хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан байна.

2.Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтаар “сурах бичиг зохиох хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж бодисоор хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх” эрх хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад олгосон байна.

Боловсролын сайдын 2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Сайд нар танаа” 1/1425 дугаар албан бичгийн хавсралт болох “Танилцуулга”-ын нэгдүгээр нүүрийн 4 дэх догол мөрийн (4)-д сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах нь бүхэлдээ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн чиг үүрэг байхаар хуульд зохицуулагдсан... гэж дурджээ. Үүнээс үзэхэд Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байх магадлалтай байна. Үүнд тайлбар өгнө үү.

3.Боловсролын ерөнхий хуулийн 38.2-т “Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломж олгох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоож санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Засгийн газрын 2022 оны “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” 91 дүгээр тогтоол батлагдаж, энэ хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны 2022 оны “Заавар батлах тухай” А/170 дугаар тушаалаар хувьсах зардлыг санхүүжүүлэх, зардлыг зарцуулах зааврыг баталж мөрдсөн. Засгийн газрын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоол батлагдаж, 8 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолоор энэхүү 39 дүгээр тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтыг хүчингүй болгосон байна.

Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоол батлагдсанаар 2022 оны 91 дүгээр тогтоол хүчингүй болсон бөгөөд үүнийг үндэслэн гарсан Боловсрол, шинжлэх ухааны 2022 оны А/170 дугаар тушаал эрх зүйн чадамжгүй болсон байна. Засгийн газрын 53 дугаар тогтоолд нийцүүлэн хувьсах зардлыг санхүүжүүлэх, зарцуулах заавар Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр А/279 дүгээр тушаалаар буюу тухайн оны хамгийн сүүлийн өдөр батлагджээ. Энэ нь 2024 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Засгийн газрын 53 дугаар тогтоол 8-12 дугаар сарын хугацаанд хэрэгжилт хангагдаагүй гэж харагдаж байна. Энэ хугацаанд Боловсролын яамнаас хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор бодлогын ямар чиглэл салбарын хэмжээнд өгч ажилласан бэ? Энэ завсрын хугацаанд хэрэгжилт дээр асуудлууд гарч байв уу?

Жишээ нь: Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих зардлыг салбарын хэмжээнд хэрхэн зарцуулсан бэ? Үүнтэй холбоотой гүйцэтгэлийн тоон мэдээлэл, мөн Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр А/279 дүгээр тушаалаар баталсан хувьсах зардлыг санхүүжүүлэх, зардлыг зарцуулах зааврын хэрэгжилт хэр үр дүнтэй явагдаж байгаа талаар тайлбар ирүүлнэ үү.

4.Боловсролын ерөнхий хуулийн 38.4-т “Энэ хуулийн 38.1.2, 38.1.3-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно”, Төсвийн тухай хуулийн 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх” гэж тус тус заасан.

Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 1/1536 дугаар, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 1/554 дүгээр, 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” 1/861 дүгээр бичгүүдээр төсвийн шууд захирагч нарт (i) багш ажилтан бүрд хоол, унааны мөнгө олгох, (ii) цэцэрлэгийн багшийн туслахад илүү цаг олгох, (iii) Хөдөлмөрийн аюулгүй байдлын нэмэгдлийг 40 хувиар олгох, (iv) хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж буй багшийн нэмэгдлийг 20 хувиар олгох зэрэг чиглэлүүд өгөгджээ. Эдгээр бичгүүд тухайн оны “батлагдсан төсөвтөө багтаана” гэх тодотголтой ажээ.

Дээрх шийдвэрүүдийг гаргахдаа 2025 оны батлагдсан төсөвтэй хэрхэн уялдуулсан бэ?, шийдвэрийн хэрэгжилттэй холбоотойгоор зарцуулалт өссөн үү?, багш ажилчдын цалин хөлс, Нийгмийн даатгалын шимтгэл, Эрүүл мэндийн даатгалын шимтгэл өссөн дүнгээр 2025 оны гүйцэтгэл ямар байдалтай байгаа бэ? Үүнтэй холбоотой тоон баримт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд эх үүсвэрийг нь тусгаагүй зардлуудыг хэрхэн санхүүжүүлсэн бэ?

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтанд олгодог 40 хувийн нэмэгдлийг төсвийн шууд захирагч нарыг өөрсдөө ав гэсэн чиглэл /орон нутгаар ажилласан Mass.mn-ийн шууд дамжуулалтаар болон салбарын удирдлагуудын шуурхай хурлаар/ өгчээ. Гэтэл боловсролын салбарын төсвийн шууд захирагч нь өөрөө ажил олгогч ба Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна”, 27.4-т “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай”-ын 1в-д ...аль нэг ажилтанд хариуцуулан цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгохоор тус тус зохицуулсан байдаг байтал ямар хууль эрх зүй үндэслэж дээрх чиглэлийг өгсөн бэ? Мөн энэхүү 40 хувийн нэмэгдэл олгох асуудал нь төсөвт хэрхэн ачаалал өгсөн бэ? Түүнийг тогтоосон судалгааг ирүүлнэ үү.

5.Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.7-д “Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ”, 12.10-т “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ”, 13 дугаар зүйлийн 13.3.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах” гэж тус тус заасан. Хуулийн дээрх заалтуудын 2025 оны хэрэгжилтийн тайлан, дүн мэдээг ирүүлнэ үү. Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалын хавсралтуудаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох журмыг баталжээ. Мэргэшлийн зэрэг горилох багш, удирдах ажилтанд тавигдах шалгуур, үзүүлэлтэд “Багшийн хөгжлийн үндэсний төв”, “Багшийн хөгжлийн бүсийн төв”-ийн анхан, ахисан шатны сургалтуудад хамрагдсан байхаар тусгасан байна. Тухайн төвүүд тус сургалтыг зохион байгуулж эхэлсэн үү? Мөн Монгол Улсын Боловсролын Их сургуулийг түшиглэн байгуулж, нээлтийг нь хийсэн “Багшийн хөгжлийн үндэсний төв”, “Багшийн хөгжлийн бүсийн төв”-үүдийн бүтэц орон тоо, төсөв, үйл ажиллагааны журам албан ёсоор батлагдсан эсэх талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

6.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Боловсролын үнэлгээ, хяналт-шинжилгээ /цаашид “боловсролын үнэлгээ” гэх/ нь сургалтын

чанарыг баталгаажуулж, багш, суралцагчийн хөгжлийг дэмжих, боловсролын бодлого, төлөвлөлтийг сайжруулахад чиглэнэ”, 26.3-т Боловсролын үнэлгээг Боловсролын ерөнхий хуулийн 17.11-д заасан Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гаргана” гэж тус тус заасан.

Боловсролын сайд үнэлгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгоно, багш, боловсролын сургалтын байгууллага өөрийгөө үнэлдэг болгоно, үнэлгээг орон нутгийн боловсролын байгууллагууд зохион байгуулдаг болно. Энэхүү шинэчлэлийг хийх ажлын хэсгийг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран байгуулж, тохирол нийцлийг шалгаж байгаа тухай 2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд албан ёсоор олон нийтэд мэдээлэл хийсэн. Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээ 4 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 03-нд, ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээ 05 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/115 дугаар тушаалаар баталсан журмын дагуу зохион байгуулагдсан байна. Энэ нь тухайн ажлын хэсэг тус шинэчлэлийг хийгээгүй гэж үзэх үү?

7.Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.10-т “энэ хуулийн 17.2, 17.11, 17.13-т заасан байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасны дагуу чөлөөлөх” гэж заасан. Боловсролын сайд нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ Боловсролын үнэлгээний төвийн захирал, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, Боловсролын зээлийн сангийн захирлын албан тушаалуудын тодорхойлолтод заасан шаардлага хангасан этгээдийг томилсон эсэх талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

8.Боловсролын сайд П.Наранбаяр өмнөх сайдын хэрэгжүүлж байсан менежментийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, “Сургуулийн судалгаа хөгжлийн Шинэ Монгол төв” ТББ-д 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон тухай хэвлэл мэдээллийн байгууллагуудад ярилцлага өгсөн. Дээрх “Сургуулийн судалгаа хөгжлийн Шинэ Монгол төв” ТББ-д 2022, 2023 болон 2024 оны эхний хагас жилд улсын төсвөөс олгосон санхүүжилтийн талаарх мэдээллийг ирүүлнэ үү.

9.Дээд боловсролын тухай хуулийн 6.2-д заасан “Монгол Улсын” болон “Үндэсний” гэсэн үг, түүний англи хэл дээрх орчуулга, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэглэнэ”, гэсэн заалтын хэрэгжилтийн тайлан ирүүлнэ үү. Тухайлбал, “Үндэсний” гэх нэртэй сургуулиудын ангилал өөрчлөхөд хуулийн холбогдох заалтыг үндэслэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг өөрчлүүлсэн байгууллагын нэрсийн жагсаалт, хэрэв өөрчлөөгүй бол шалтгаан тайлбарыг хамт ирүүлнэ үү.

10.2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасан дээд сургуулийг их сургууль, эсхүл коллеж болгох шилжилтийн үйл ажиллагааг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна гэж заасан. Тус хуулийн хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 253 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалт”-ын дагуу дээд боловсролын байгууллагын ангиллыг тогтоох ажлын хэсэг байгуулсан, удирдамж баталсан тушаал, дээд сургуулиудыг ангиллын шаардлага хангасан эсэх ажлын хэсгийн дүгнэлт (шалгуур бүрээр), дээд боловсролын зөвлөлийн тэмдэглэл, түүнийг үндэслэн гаргасан сайдын тушаалын хуулбар, холбогдох шийдвэр гаргах явцад хянасан албан тушаалтны гарын үсэг, өгсөн саналын хамт тогтоосон хугацаанд ирүүлнэ үү.

11.Дээд сургуулийг “их сургууль” болгосон, эсхүл “коллеж” болгосон шийдвэрийг элсэлтээс өмнө элсэгч, эцэг эх, олон нийтэд хүргэж сурталчилсан талаарх үйл ажиллагааны

2025000040

мэдээлэл болон элсэлт үйл ажиллагааг их сургууль, коллеж гэсэн ангиллаар зохион байгуулж байгаа сургуулиудын жагсаалтыг гаргаж ирүүлнэ үү.

12.Дээд боловсролын хуулийн 12.9-д заасан “Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.13-т заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” гэсэн заалтын дагуу олон улсын “THE-Times Higher Education” байгууллагатай хамтран эрэмбэ хийж зарласан. Жинхэнэ эрэмбэ тогтоох ажлын хэсэг гарч эрэмбийн үр дүнг тайлан болгож, Боловсролын үнэлгээний төвийн даргын албан бичгээр Боловсролын яаманд хүргүүлсэн байна. Жинхэнэ эрэмбийг албан ёсоор зарласан, олон нийтэд ил тод мэдээлэл хийсэн эсэх, их сургууль, коллежид элсэгч болон эцэг, эхчүүдэд нээлттэй мэдээлэл хэрхэн хүргэсэн талаарх ажлын тайлан ирүүлнэ үү.

13.Дээд боловсролын тухай хуулийн 12.12-д заасан “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно” гэж заасан. ЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын болон дотоодын дээд сургуульд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын 4.5.3, 6.2.3, 7.3.3, 8.4.3, 10.3.3-д заасан нөхцөлийн дагуу 2024-2025 оны суралцагчдад олгосон эсэх талаар салбарын хяналтын тайлан, дүгнэлтийг нотлох баримтын хамт албан бичгээр ирүүлнэ үү.

14.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчийн тогтмол зардлыг санхүүжүүлэх журмын “Хоёр.Тогтмол зардал олгоход тавих шаардлага”-ыг баримтлан 2024-2025 оны хичээлийн жилд санхүүжилт олгосон эсэхэд хийсэн хяналт, шинжилгээний тайлан, санхүүжилт хийснээр бий болсон үр дүнгийн тайланг ирүүлнэ үү.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.БАТ-ЭРДЭНЭ

2025000040